ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**Улсын бүртгэлийн хэлтсийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

**Аудитын код: ОРА-2021-/88/-СТА-ТШ3**

Цахим хуудас: www.audit.mn

Орхон аймаг

2021 он


Тэргүүлэх аудитор: Ц.Нармандах

Утас:70359826

Цахим хаяг:orkhon@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Эрдэнэ

Утас:70355805

Цахим хаяг:erdeneb@audit.gov.mn

Аудитор: Б.Азжаргал

Утас:70350757

Цахим хаяг: ajzargalb@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт ..... 3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан ..... 5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ..... 5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ..... 5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ..... 7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..... 8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 10
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан ..... 11
3. Аудитын тайлан ..... 11
3.1. Ерөнхий зүйл ..... 11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй ..... 12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт ..... 12
3.4. Материаллаг байдал ..... 12
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ..... 12
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт ..... 13
3.7. Шилэн дансны мэдээлэл ..... 15
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 15
3.9. Аудитын илрүүлэлт ..... 15
Залруулсан алдаа ..... 15
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил ..... 15
Аудитын зөвлөмж ..... 15
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд ..... 15
4. Менежментийн захидал ..... 155
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт ..... 186

## 1.Төрийн аудитын санал, дүгнэлт

ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn
2021.02.22. № 10
танай_____________-ны № _______________-т

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА М.ОТГОНБАЯР ТАНАА

### Аудитын санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улсын бүртгэлийн хэлтсийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

**Зөрчилгүй дүгнэлт**

Улсын бүртгэлийн хэлтсийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

D:\my doc \albanbichig\ 2021-A4.doc

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРМАНДАХ

# 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан
## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

**САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 31,999,643.60 | 31,698,268.49 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 31,999,643.60 | 31,698,268.49 |
| 351 | Түүхий эд материал | 12,075,023.10 | 13,952,450.75 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 12,075,023.10 | 13,952,450.75 |
| 354 | Хангамжийн материал | 19,395,395.50 | 16,616,592.74 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 2,972,716.50 | 1,750,113.74 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 6,995,694.00 | 6,049,694.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 00.00 | 59,600.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 9,426,985.00 | 8,757,185.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 41,771,709.41 | 31,818,046.37 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 41,771,709.41 | 31,818,046.37 |
| 392 | Биет хөрөнгө | 41,771,709.41 | 31,818,046.37 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 58,000,000.00 | 58,000,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -58,000,000.00 | -58,000,000.00 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 164,946,193.31 | 166,585,039.31 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -148,136,815.18 | -154,579,203.22 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 52,164,870.00 | 52,164,870.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -27,202,538.72 | -32,352,659.72 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 73,771,353.01 | 63,516,314.86 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 73,771,353.01 | 63,516,314.86 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 73,771,353.01 | 63,516,314.86 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 148,156,954.32 | 148,156,954.32 |
| 51101 | Өмч: - төрийн | 148,156,954.32 | 148,156,954.32 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | -88,750,982.31 | -84,640,639.46 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -88,750,982.31 | -74,385,601.31 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -10,255,038.15 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 14,365,381.00 | 00.00 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 73,771,353.01 | 63,516,314.86 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

**САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 406,419,063.83 | 529,814,484.55 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 17,965,963.83 | 30,243,384.55 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 17,965,963.83 | 30,060,124.55 |

| | | | |
|---|---|---|---|
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 747,606.00 | 00.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 17,218,357.83 | 30,060,124.55 |
| 120009 | Бусад орлого | 00.00 | 183,260.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 388,453,100.00 | 499,571,100.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 362,253,100.00 | 392,249,900.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 362,253,100.00 | 392,249,900.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 26,200,000.00 | 107,321,200.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 26,200,000.00 | 25,200,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 82,121,200.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 419,430,409.59 | 540,069,522.70 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 419,430,409.59 | 540,069,522.70 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 410,433,571.59 | 535,543,154.28 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 293,119,825.00 | 321,241,557.49 |
| 210101 | Үндсэн цалин | 248,582,490.00 | 200,644,480.49 |
| 210102 | Нэмэгдэл | 24,742,580.00 | 94,603,544.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 2,970,000.00 | 5,336,100.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 16,824,755.00 | 20,657,433.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 38,575,002.00 | 43,790,800.09 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 26,871,221.00 | 30,773,463.09 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,978,746.00 | 3,388,900.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,326,677.00 | 2,583,440.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 581,668.00 | 640,454.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,816,690.00 | 6,404,543.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 28,762,567.00 | 31,236,086.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,561,912.00 | 5,102,514.00 |
| 210302 | Түлш, халаалт | 3,086,822.00 | 3,094,858.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,846,633.00 | 1,922,410.00 |
| 210304 | Байрны түрээс | 19,267,200.00 | 21,116,304.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 12,518,711.50 | 20,024,065.26 |
| 210401 | Бичиг хэрэг | 7,721,966.00 | 10,651,361.76 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,766,800.00 | 1,185,700.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,180,403.00 | 1,109,657.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 64,000.00 | 00.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 361,300.00 | 1,056,100.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 424,242.50 | 6,021,246.50 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,503,300.00 | 5,103,666.55 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 00.00 | 238,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 00.00 | 1,623,266.55 |
| 210604 | Урсгал засвар | 1,503,300.00 | 3,242,400.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 2,740,000.00 | 287,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,740,000.00 | 287,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 19,358,651.70 | 20,038,795.85 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 800,000.00 | 390,100.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 540,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 117,612.00 | 98,010.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 58,080.00 | 59,480.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 22,000.00 | 22,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 18,360,959.70 | 18,929,205.85 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 13,855,514.39 | 93,821,183.04 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 00.00 | 81,938,315.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 978,100.00 | 563,500.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 12,877,414.39 | 11,319,368.04 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 8,996,838.00 | 4,526,368.42 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 3,720,000.00 | 384,600.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,720,000.00 | 384,600.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 1,574,059.00 | 3,958,883.42 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,574,059.00 | 3,958,883.42 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 3,702,779.00 | 182,885.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | -13,011,345.76 | -10,255,038.15 |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 12,969,490.16 | 00.00 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 12,969,490.16 | 00.00 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | -12,969,490.16 | 00.00 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | -25,980,835.92 | -10,255,038.15 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 719,888,459.06 | 801,725,081.27 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 331,435,359.06 | 302,153,981.27 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 331,435,359.06 | 302,153,981.27 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 331,435,359.06 | 302,153,981.27 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 331,435,359.06 | 302,153,981.27 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 388,453,100.00 | 499,571,100.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 362,253,100.00 | 392,249,900.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 362,253,100.00 | 392,249,900.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 26,200,000.00 | 107,321,200.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 26,200,000.00 | 25,200,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 82,121,200.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 719,888,459.06 | 801,725,081.27 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 719,888,459.06 | 801,725,081.27 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 379,456,262.00 | 495,044,731.58 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 292,372,219.00 | 321,058,297.49 |
| 210101 | Үндсэн цалин | 220,937,700.00 | 244,005,297.86 |
| 210102 | Нэмэгдэл | 41,295,010.00 | 49,595,558.67 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 13,230,777.00 | 6,312,440.96 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 00.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 16,908,732.00 | 21,145,000.00 |
| 210106 | Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/ | 00.00 | 00.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 38,575,002.00 | 43,790,800.09 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 26,881,102.00 | 31,601,235.98 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,604,400.00 | 3,066,068.92 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,083,500.00 | 2,432,515.16 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 520,900.00 | 608,353.76 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,485,100.00 | 6,082,626.27 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 28,762,567.00 | 31,236,086.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,561,912.00 | 5,102,514.00 |
| 210302 | Түлш, халаалт | 3,086,822.00 | 3,094,858.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,846,633.00 | 1,922,410.00 |
| 210304 | Байрны түрээс | 19,267,200.00 | 21,116,304.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 11,507,133.00 | 8,556,943.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 6,429,830.00 | 5,145,886.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,766,800.00 | 1,245,300.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,180,403.00 | 1,109,657.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 64,000.00 | 00.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,066,100.00 | 1,056,100.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2,978,349.00 | 6,254,100.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 870,000.00 | 797,000.00 |
| 210602 | Тавилга | 00.00 | 00.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 610,000.00 | 1,066,800.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,498,349.00 | 4,390,300.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 2,740,000.00 | 287,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,740,000.00 | 287,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 997,692.00 | 1,109,590.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 800,000.00 | 390,100.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 540,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 117,612.00 | 98,010.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 58,080.00 | 59,480.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 22,000.00 | 22,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,523,300.00 | 82,751,915.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 00.00 | 81,938,315.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,523,300.00 | 813,600.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 340,432,197.06 | 306,680,349.69 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 3,720,000.00 | 384,600.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,720,000.00 | 384,600.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 333,009,418.06 | 306,112,864.69 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,574,059.00 | 3,958,883.42 |
| 213306 | Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг | 331,435,359.06 | 302,153,981.27 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 3,702,779.00 | 182,885.00 |
| 213405 | Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг | 3,702,779.00 | 182,885.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

## ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | 2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 148,156,954.3 | 14,365,381.0 | (62,770,146.4) | 99,752,188.9 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 148,156,954.3 | 14,365,381.0 | (62,770,146.4) | 99,752,188.9 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний  бууралт | - | - | - | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | (25,980,835.9) | (25,980,835.9) |
| C08 | 2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 148,156,954.3 | 14,365,381.0 | (88,750,982.3) | 73,771,353.0 |
| D01 | 2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 148,156,954.3 | 14,365,381.0 | (88,750,982.3) | 73,771,353.0 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | 14,365,381.0 | 14,365,381.0 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 148,156,954.3 | 14,365,381.0 | (74,385,601.3) | 88,136,734.0 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | (14,365,381.0) | - | (14,365,381.0) |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | - |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | (10,255,038.2) | (10,255,038.2) |
| D09 | 2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 148,156,954.3 | - | (84,640,639.5) | 63,516,314.9 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 392,249,900.00 | 388,291,016.58 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 392,249,900.00 | 388,291,016.58 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 391,865,300.00 | 387,906,416.58 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 299,913,300.00 | 299,913,297.49 |
| 210101 | Үндсэн цалин | 252,310,500.00 | 244,005,297.86 |
| 210102 | Нэмэгдэл | 41,266,800.00 | 49,595,558.67 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 6,336,000.00 | 6,312,440.96 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 00.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 00.00 | 00.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 42,130,300.00 | 39,735,800.09 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 30,133,800.00 | 27,546,235.98 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,999,100.00 | 3,066,068.92 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,399,300.00 | 2,432,515.16 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 599,800.00 | 608,353.76 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,998,300.00 | 6,082,626.27 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 31,512,000.00 | 31,236,086.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,680,000.00 | 5,102,514.00 |
| 210302 | Түлш, халаалт | 4,351,800.00 | 3,094,858.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,688,000.00 | 1,922,410.00 |
| 210304 | Байрны түрээс | 20,792,200.00 | 21,116,304.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 9,450,400.00 | 8,556,943.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,147,500.00 | 5,145,886.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,245,300.00 | 1,245,300.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,964,500.00 | 1,109,657.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 37,000.00 | 00.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,056,100.00 | 1,056,100.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 6,257,600.00 | 6,254,100.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 800,500.00 | 797,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 1,066,800.00 | 1,066,800.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,390,300.00 | 4,390,300.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 330,000.00 | 287,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 330,000.00 | 287,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,458,100.00 | 1,109,590.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 627,600.00 | 390,100.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 540,000.00 | 540,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 120,000.00 | 98,010.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 148,500.00 | 59,480.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 22,000.00 | 22,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 813600.00 | 813600.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 813,600.00 | 813,600.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 384600.00 | 384600.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 384,600.00 | 384,600.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 384,600.00 | 384,600.00 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 392,249,900.00 | 392,249,900.00 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 392,249,900.00 | 392,249,900.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 392,249,900.00 | 392,249,900.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

## 3.Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Орхон аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг хэлтсийн дарга М.Отгонбаяр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25–ны хооронд төлөвлөн, Орхон аймаг дахь төрийн аудитын менежер Б.Эрдэнэ, аудитор Б.Азжаргал нар хариуцан гүйцэтгэнэ.

Орхон аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 22-ний өдрийн 127 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

## 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Улсын бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь: Иргэнд суурилсан төрийн бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, иргэний эрхийг хангах, төрийн ой санамжийг бүрдүүлэх, бэхжүүлэх үйл ажиллагааг Монгол улсын хууль тогтоомж, олон улсын гэрээ хэлэлцээр болон Монгол улсын хөгжлийн өнөөгийн шаардлагад нийцүүлэн олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн нийтлэг жишигт хүргэхэд оршино.

Улсын бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Аймгийн хэмжээнд хуульд заасан иргэний, эд хөрөнгийн, хуулийн этгээдийн бүртгэлийг эрхлэн хөтлөх
- Улсын бүртгэлтэй холбоотой үйлчилгээг иргэн, аж ахуй нэгжүүдэд үзүүлэх
- Аймаг, сумдын улсын бүртгэгчийн үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт ороогүй байна.

## 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Орхон аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

## 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

## 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Орхон аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 10,255.0 мянган төгрөгөөр буюу 13,9 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0 | 0 | 0 |
| Авлага | 0 | 0 | 0 |
| Урьдчилгаа | 0 | 0 | 0 |
| Бараа материал | 31,999.6 | 31,698.3 | -301.3 |
| Үндсэн хөрөнгө | 41,771.7 | 31,818.0 | -9,953.7 |
| **Нийт хөрөнгө** | 73,771.3 | 63,516.3 | -10,255.0 |
| Өр төлбөр | 0 | 0 | 0 |

| | | | |
|---|---|---|---|
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 73,771.3 | 63,516.3 | -10,255.0 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 73,771.3 | 63,516.3 | -10,255.0 |

Бараа материалын дансны үлдэгдэл 31,698.3 мянган төгрөг болж 301.3 мянган төгрөгөөр буурсан нь тусгай зориулалтын материалын зарцуулалтаас болон 6,021.2 мянган төгрөгийн бараа материал акталж данснаас хассанаас шалтгаалжээ.

УБЕГ-с тайлант хугацаанд 28,694.4 мянган төгрөгийн бараа материал хүлээн авч үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоор бүртгэсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 31,818.0 мянган төгрөг болж 9,953.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд байгуулсан элэгдэлээс шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс үнэ төлбөргүй шилжиж ирсэн 1,638.8 мянган төгрөгийн өртөгтэй, 273.1 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Улсын бүртгэлийн хэлтсийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 123,395.4 мянган төгрөгөөр буюу 30,3 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээн авсан орлого болон нэмэлт санхүүжилтийн орлого байна. Энэ нь УИХ-ын болон АНСДИТХ-ын ээлжит сонгуулиуд болсонтой холбоотойгоор УБЕГ-с хуваарилсан сонгууль зохион байгуулахад шаардагдах зардал болон бараа материал байна.

Нийт зардал өмнөх оноос 120,639.1 мянган төгрөгөөр буюу 28,8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан Цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал байна. Энэ нь Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 472 дугаар тогтоолоор цалин нэмэгдсэнтэй холбоотой

## 3.6. ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ, НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 426,468.8 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 426,468.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 34,218.9 мянган төгрөгөөр бууруулж 392,249.9 мянган төгрөгөөр баталсан байна.

### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 392,249.9 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 392,249.9 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 25,200.0 мянган төгрөгийн, дээд шатны төсвийн захирагчаас 82,121.2 мянган төгрөгийн санхүүжилт тус тус авч, нийт 499,571.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 495,429.3 мянган төгрөгийг зарцуулж, 4,141.8 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 495,429.3 мянган төгрөг буюу 99.1 хувьтай байгаа нь Ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 2,394.5 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 893.5 мянган төгрөгөөр тус тус хэмнэн зарцуулсантай холбоотой байна.

Төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь Улсын бүртгэл, мэдээлэл хөтөлбөрийн Үндсэн үйл ажиллагааны зардал арга хэмжээ 3,958.9 мянган төгрөгөөр, УИХ-ын сонгууль арга хэмжээ 6.9 мянган төгрөгөөр, Орон нутгийн сонгууль арга хэмжээ 175.9 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

### Улсын төсөвт төвлөрүүлэх орлого

Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд зааснаар 2020 онд 320,000.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 302,154.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 94.4 хувиар биелүүлсэн байна.

*Хүснэгт 2* Төвлөрүүлэх орлого /мянган төгрөг/

| Орлогын төрөл | Төлөв | Гүйц | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| Шилжилт хөдөлгөөн | 7,301.2 | 6,894.0 | -407.2 | 94.4% |
| Архивын лавлагаа | 25,868.1 | 24,425.5 | -1,442.6 | 94.4% |
| Иргэний гэр бүлийн байдлын бүртгэл | 5,069.7 | 4,787.00 | -282.7 | 94.4% |
| Эд хөрөнгийн эрхийн бүртгэл | 195,312.7 | 184,420.4 | -10,892.3 | 94.4% |
| Хуулийн этгээдийн бүртгэл | 299.7 | 283.0 | -16.7 | 94.4% |
| Иргэний үнэмлэх | 86,148.5 | 81,344.1 | -4,804.4 | 94.4% |
| **Нийт дүн** | 320,000.0 | 302,154.0 | -17,846.0 | 94.4% |

Үндсэн үйл ажиллагааны орлого 17,846.0 мянган төгрөгөөр тасарсан шалтгаан нь Улсын болон орон нутгийн сонгууль мөн ковид-19 өвчний тархалтаас шалтгаалан Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжиж хөл хорио тогтоосны улмаас 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 01-ны өдөр хүртэл хэлтсийн үйл ажиллагаа бүрэн зогссонтой холбоотой байна.

### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засгийн газрын нөөц сангаас 25,200.0 мянга, дээд шатны төсвийн захирагчаас 82,121.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс Гэрээт ажилтнуудын цалин, АО-с төлөх НДШ-д 25,200.0 мянга, УИХ-ын сонгуулийн бэлтгэл ажилд 52,395.3 мянга, Орон нутгийн сонгуульд 29,543.0 мянга, нийт 107,138.3 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 182,8 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөвлөмж өгсөнөөс хэрэгжилт 100 хувьтай байна.

*Хүснэгт 3* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган.төг/

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 0 | | | | | | |
| Албан шаардлага | 0 | | | | | | |
| Зөвлөмж | 2 | | 2 | | | | |
| Нийт дүн | 2 | | 2 | | | | |

### 3.9. Аудитын илрүүлэлт

Шатахууны норм хүйтэн, дулааны улирлаас үл хамааран өөрчлөлтгүй, шатахуун зарцуулалтын жишиг нормоос өндрөөр шатахууныг 800.0 мянган төгрөгийн илүү тооцож олгосон зөрчилд зөвлөмж өглөө.

**Залруулсан алдаа** Улсын бүртгэлийн 2020 он санхүүгийн тайлангаар ямар нэгэн залруулга хийгдээгүй байна.

#### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

#### Аудитын зөвлөмж

Аудитаар Засгийн газраас тогтоосон цилиндрийн хэмжээнээс их багтаамжтай автомашин хэрэглэснээс шатахуун, бусад зардлыг батлагдсан төсвөөс хэтрүүлэн зарцуулсан 800.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд зөвлөмж өгч менежментийн захидалд тусгав.

### 3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Улсын бүртгэлийн 2020 он санхүүгийн тайлангийн аудитаар анхаарах асуудал алга байна.

## 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

**Зардлын данстай холбоотой асуудал**

1.1. **Илрүүлэлт:** Шатахууны норм хүйтэн, дулааны улирлаас үл хамааран өөрчлөлтгүй, шатахуун зарцуулалтын жишиг нормоос өндрөөр шатахууныг 800.0 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон

1.2. **Эрсдэл:** Зардлыг буруу тооцоолж бүртгэсэн, анхан шатны баримтгүй, зөвшөөрөлгүй зардал гаргасан

1.3. **Өгсөн зөвлөмж:** Монгол Улсын Засгийн газрын 184 тогтоол, Зам тээврийн хөгжлийн сайдын 390 тушаал зэргийг мөрдөж ажиллах талаар зөвлөмж хүргүүллээ.

**Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Төсвийн захирагчийн 2021.02.18-ны өдрийн 276 тоот албан бичгээр хэрэгжүүлж ажиллахаа мэдэгдсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### ТАЙЛАН БИЧСЭН:

| | | |
|---|---|---|
| Бэлтгэсэн: Аудитор | Б.Азжаргал | Огноо |
| Анхан шатанд хянасан: Аудитын менежер | Б.Эрдэнэ | Огноо |
| Хоёр дахь шатанд хянасан: Дарга, тэргүүлэх аудитор | Ц.Нармандах | Огноо |

Улсын бүртгэлийн хэлтсийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

**Аудитын зөвлөмж**

Аудитаар Засгийн газраас тогтоосон цилиндрийн хэмжээнээс их багтаамжтай автомашин хэрэглэснээс шатахуун, бусад зардлыг батлагдсан төсвөөс хэтрүүлэн зарцуулсан 800.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд зөвлөмж өгч менежментийн захидалд тусгав.

**3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

Улсын бүртгэлийн 2020 он санхүүгийн тайлангийн аудитаар анхаарах асуудал алга байна.

## 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

**Зардлын данстай холбоотой асуудал**

1.1. ***Илрүүлэлт:*** Шатахууны норм хүйтэн, дулааны улирлаас үл хамааран өөрчлөлтгүй, шатахуун зарцуулалтын жишиг нормоос өндрөөр шатахууныг 800.0 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон

1.2. ***Эрсдэл:*** Зардлыг буруу тооцоолж бүртгэсэн, анхан шатны баримтгүй, зөвшөөрөлгүй зардал гаргасан

1.3. ***Өгсөн зөвлөмж:*** Монгол Улсын Засгийн газрын 184 тогтоол, Зам тээврийн хөгжлийн сайдын 390 тушаал зэргийг мөрдөж ажиллах талаар зөвлөмж хүргүүллээ.

*Байгууллагаас өгсөн хариу тайлбар:* Төсвийн захирагчийн 2021.02.18-ны өдрийн 276 тоот албан бичгээр хэрэгжүүлж ажиллахаа мэдэгдсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛЫГ**

| | | |
|---|---|---|
| Бэлтгэсэн: Аудитор | Б.Азжаргал | Огноо 2/18 |
| Анхан шатанд хянасан: Аудитын менежер | Б.Эрдэнэ | Огноо |
| Хоёр дахь шатанд хянасан: Дарга, тэргүүлэх аудитор | Ц.Нармандах | Огноо 2/22 |

6117143600
ФАА0073 0042808

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:20 2021

Аудитын нэр: Улсын бүртгэлийн хэлтсийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн

Аудитын код: ОРА-2021/88/СТА-ТШЗ

Шалгагдсан байгууллагын нэр: **Улсын бүртгэлийн хэлтэс**

Мянган төгрөг

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Шатахууны норм хүйтэн, дулааны улирлаас үл хамааран өөрчлөлтгүй, шатахуун зарцуулалтын жишиг нормоос өндрөөр тооцож олгосон | 800.0 | Зөвлөмж | Улсын бүртгэлийн хэлтсийн дарга, нягтлан бодогч | М.Отгонбаяр Ц.Одгэрэл |
| 2 | | | | | |
| 3 | | | | | |
| **ДҮН** | | **800.0** | | | |

Бэлтгэсэн: Аудитор Б.Азжаргал Огноо

Анхан шатанд хянасан: Аудитын менежер Б.Эрдэнэ Огноо

Хоёр дахь шатанд хянасан: Дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах Огноо

Улсын бүртгэлийн хэлтсийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:20 2021

Аудитын нэр: Улсын бүртгэлийн хэлтсийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Аудитын код: ОРА-2021/88/СТА-ТШЗ

Шалгагдсан байгууллагын нэр: **Улсын бүртгэлийн хэлтэс**

Мянган төгрөг

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Шатахууны норм хүйтэн, дулааны улирлаас үл хамааран өөрчлөлтгүй, шатахуун зарцуулалтын жишиг нормоос өндрөөр тооцож олгосон | 800.0 | Зөвлөмж | Улсын бүртгэлийн хэлтсийн дарга, нягтлан бодогч | М.Отгонбаяр Ц.Одгэрэл |
| 2 | | | | | |
| 3 | | | | | |
| **ДҮН** | | **800.0** | | | |

Бэлтгэсэн: Аудитор Б.Азжаргал Огноо 5/15

Анхан шатанд хянасан: Аудитын менежер Б.Эрдэнэ Огноо

Хоёр дахь шатанд хянасан: Дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах Огноо 11/22

6117143890 ФАА0073 9042806